



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үндэсний хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 36,850,000.00 (гучин зургаан сая найман зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 14,000,000.00 (арван дөрвөн сая) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000742

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн
404 дугаар тогтоолын хавсралт

**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Ашиглалтын хугацаа сунгах	Шинэчилсэн үнэ
			(төгрөг)	(жил)	(Төгрөг)
1	Хьюндай Соната 7, 05-30 УНУ, KMHEB41AADA566304	2013/2013	36,850,000.00	2	14,000,000.00
Нийт дүн			36,850,000.00		14,000,000.00
			(гучин зургаан сая найман зуун тавин мянга)	-	(арван дөрвөн сая)